



**МОНГОЛРОСЦВЕТМЕТ**  
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

13341 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайваны өргөн чөлөө 98, 22 дугаар хороо  
Утас: 45 80 72, Факс: (976-11) 45 83 80, 45 84 30,  
И-мэйл: mailbox@monros.mn, Вэб сайт: www.mongolros.mn

2024.12.05. № 1/2453

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хариу хүргүүлэх тухай**

Танай байгууллагаас ирүүлсэн 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/1979 дугаартай албан бичигтэй танилцлаа.

Тус ТӨҮГ нь уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд, CAT980 серийн дугуйт ачигчуудыг уурхайн хүдрийн болон хөрсний овоолгоос ачилт хийх, төмөр замын ачилтын талбайгаас ачааны вагонуудад ачилт хийх, овоолго бүрдүүлэх ажиллагаанд ашигладаг тул тоосжилт маш ихтэй орчинд ажилладаг учир шүүр, шүүлтүүрийн хийц, чанарт онцгой нөхцөл, үзүүлэлт шаардагддаг.

"CAT980H, CAT980F автоачигчийн сэлбэг" худалдан авах МРЦМ/20240102161 дугаартай тендер шалгаруулалтад тодорхойлолтод заасан сэлбэг материалын жагсаалтад CAT980 серийн автоачигчийн 11 төрлийн 106 ш агаар шүүгч багтсан.

Гомдол гаргасан "Альфа филтер" ХХК-ийн үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнүүдийг тус компанийн alfa-filter.mn цахим хуудас дахь Е-Каталоги -> ШҮҮЛТҮҮР хэсэгт байршуулсан мэдээллийн дагуу судалж үзэхэд жижиг болон дунд оврын тээврийн хэрэгсэлд зориулагдсан шүүлтүүрүүд байгаа бөгөөд манайд шаардлагатай төрөл, эдийн дугаар бүхий агаар шүүгч, шүүр, шүүлтүүрүүдийг тус компани үйлдвэрлэдэггүй байна.

Уул уурхайн зориулалттай хүнд машин механизм болон тусгай зориулалтын техникүүдэд ашигладаг чанар, стандартын шаардлага хангасан шүүр, шүүлтүүрүүдийг үйлдвэрлэдэг дотоодын үйлдвэрлэгч байхгүй учир дотоодын үйлдвэрлэгчээс худалдан авах боломжгүй гэж үзээд, техникийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын чанар, хугацааг тооцон бусад сэлбэгүүдтэй хамт худалдан авахаар зохион байгуулсан.

Иймд дээрх МРЦМ/20240102161 дугаартай "CAT980H, CAT980F автоачигчийн сэлбэг" худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулахгүйгээр үргэлжлүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар шийдвэрлэсэн болохыг мэдэгдэж байна.

ЗАХИРАЛ



Д.ТОГТОХСҮРЭН

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

1334142973